



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/86

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II хуралдааны аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр, 2023 оны XIX хуралдааны Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай 2023 оны XIX/08 дугаар, 2023 оны XIX хуралдааны “Алтаргана 2024” наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх хугацааг тогтоох тухай 2023 оны XIX/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн явц, гарсан үр дүн, “Алтаргана 2024” наадмыг зохион байгуулах бэлтгэл ажил, уралдаан тэмцээн, наадмын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлах хэвлэл мэдээллийн хэрэгслийг хавсралтаар баталсугай.


2. Хавсралтад тусгагдсан 17 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, холбогдох зардал 125,000,000 (нэг зуун хорин таван сая) төгрөгийг Булган аймаг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын 2024 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024 оны
02 дугаар сарын 22-ны /ний өдрийн / 86 дугаар
захирамжийн хавсралт



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ

д/д	Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нэр	Үнийн дүн
1	2	3
1	MNB	30.000.000
2	Сайхан монгол ТВ	20.000.000
3	Цахиурын дуу хоолой ТББ www.tsahiur.mn	7.000.000
4	“Чемкагийн хүүхдүүд” НҮТББ www.utga.mn	5.000.000
5	“Булганы мэдээ” сонин	5.000.000
6	Мэдээллийн пи ар агентлаг НҮТББ www.dardas.mn	5.000.000
7	www.erdenetinfo.mn	5.000.000
8	“Иргэний сэтгүүл зүйн боловсрол” ТББ https://todaynews.mn/	4.000.000
9	“Сэтгүүлчдийн цахим сүлжээ” ТББ https://www.erdenetlife.mn/	5.000.000
10	“ЭРЭГ ЭРДЭНЭТ” ТББ www.etzone.mn	5.000.000
11	“Ган үзэгтэн” ХХК www.zarig.mn	5.000.000
12	“Мэдээллийн индэр” ТББ www.inder.mn	5.000.000
13	“Буйлхан ногоон хөгжил” ТББ Bulgan podcast	5.000.000
14	“Ашин Булган” ХХК	5.000.000
15	Булган хангай	5.000.000
16	HELLO BULGAN	5.000.000
17	Булган медиа	4.000.000
	Нийт дүн	125.000.000